

## ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 01 дүгээр  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүргийн хүрээнд 2021 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллалаа.

### **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

Монгол Улсын 6 хуулийн 14, Улсын Их Хурлын 7 тогтоолын 24, Улсын Их Хурлын Байнгын хорооны 8 тогтоолын 22, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 зарлигийн 17, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 зөвлөмжийн 12, Засгийн газрын 10 тогтоолын 13, Засгийн газрын хуралдааны 11 тэмдэглэлийн 23, Засгийн газрын 1 албан даалгаврын 2, нийт 49 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 127 арга хэмжээ, зүйл заалт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний цагдаагийн байгууллагад хамаарах 30 заалтын хэрэгжилтийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 01/1026 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнасан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд “Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах”, “Үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангах” гэсэн зорилтыг дэвшүүлэн, Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2021 оны А/95 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 194, 209, 226 дугаар, 2021 оны 27, 45, 78, 91, 105, 115, 118 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 12, 2021 оны 01, 02, 04 дүгээр тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас хүн амыг урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын бие бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 3 удаа, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт 2 удаа тус тус шилжүүлэн ажиллуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн 2021 оны хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлуулж, нийт 10 удаа хуралдан, хуралдаанаас гарсан шийдвэр, мэдээлэл, үүрэг, ажлын чиглэлийг холбогдох анги, байгууллагад тухай бүр хүргүүлж, үр дүнг тооцон ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас болон Тэргүүн дэд, Дэд, Захиргааны удирдлагын газрын дарга нараас цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан байгууллагын үндсэн үйл ажиллагаанд чиглэсэн 475 тушаал, 91 удаагийн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж өгснийг анги, байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг тооцсон.

**1.1.Соён гэгээрүүлэх, албаны сургалтын чиглэлээр:** “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний дагуу албаны 4772 удаагийн сургалтад давхардсан тоогоор 694052, “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх давтан, мэргэшүүлэх 2021 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу танхимын болон цахим 147 удаагийн 3245 цагийн сургалтад 14258 алба хаагчийг хамруулан үр дүнг тооцож, “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний дагуу 4624 удаа соёл, хүмүүжлийн мэдээлэл, сурталчилгааг давхардсан тоогоор 987863 алба хаагчид хүргэж ажилласан.

Шинээр болон шилжин томилогдсон алба хаагчдад байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журмуудыг судлуулах зорилгоор гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн 229, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн 47, замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлийн 107, Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах чиглэлийн 58, шуурхай бэлэн байдлын чиглэлийн 75 удаагийн сургалтыг

төрийн захиргаа, хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулж давхардсан тоогоор 46823 алба хаагчийг хамруулсан.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран алба хаагчдыг сурган зааварчлах сургагч багш бэлтгэх 4 удаагийн сургалтаар 220, Үндэсний бичгийн сургагч багш бэлтгэх сургалтад 42, Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшаар 54, Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийг биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах сургагч багшаар 42 анги, байгууллагын 51 алба хаагчийг сургаж бэлтгэсэн.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалтад 2215 алба хаагч, иргэн болон гэрээт харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх 3 удаагийн сургалтад 32 байгууллагын 170 иргэн, олон нийтийн цагдаагаар 186 иргэн, цагдаа, цагдаа-жолооч, дотоодын цэргийн харуулчин мэргэжил олгох сургалтад 1620 иргэнийг сургаж гэрчилгээ олгосон.

Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг дээшлүүлэх зорилгоор дотоод, гадаадын их дээд сургуулиудтай хамтран ажиллаж, цагдаагийн байгууллагын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын боловсролын эчнээ хөтөлбөрийн сургалтад 138, магистрын хөтөлбөрийн сургалтад 45, докторын хөтөлбөрийн сургалтад 13, Удирдлагын сургуульд 20, ОХУ, БНХАУ, БНТУ, БНСУ, БНУУ зэрэг 5 улсын цагдаагийн байгууллага, академи, их, дээд сургуульд боловсролын адъюнктур, доктор, магистрантур, бакалаврын сургалтад 91, нийт 307 алба хаагчийг суралцуулж байна.

Олон улсад магадлан итгэмжлэгдсэн “Wall Street English” сургалтын төвд 20, Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэдэх Гадаад хэлний сургалтын төвд 1, Дотоодын цэргийн штабын гадаад хэлний сургалтад 173, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн гадаад хэлний сургалтад 20 алба хаагчийг сургасан.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Улсын онцгой комисс, эрүүл мэндийн байгууллагаас өгч буй зөвлөмжийн дагуу Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх удирдах ажилтан, офицер, ахлагч бүрэлдэхүүний сургалт зөвлөгөөнийг 54 байршлаас анх удаа цахимаар зохион байгуулж 512 удирдах ажилтан, 2688 ахлагч, 3671 офицер бүрэлдэхүүнийг хамруулсан.

Олон улсын байгууллагаас тодорхой төрлийн гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан сүлжээний администратор, CCNA, CCNP сургалтад 1, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх сургалтад 11, цахим орчин дахь гэмт хэргийг мөрдөн шалгах сургалтад 11, зохион байгуулалттай гэмт хэрэг мөрдөн шалгах сургалтад 4, кибер гэмт хэргийг мөрдөн шалгах сургалтад 23 алба хаагчийг хамруулж, гүйцэтгэх ажлын эрх олгох мэргэшүүлэх сургалтад 144 алба хаагчийг хамруулж гэрчилгээ олгосон.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд дэвшүүлсэн “Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах” нэгдүгээр зорилтыг хэрэгжүүлэх, алба хаагчдыг гэмт хэрэг, сахилга, ёс зүйн зөрчил, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, бууруулах, алба хаагч, ажилтны эрх хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор “Харилцаа, Хандлага” аяныг зохион байгуулж, нийт 7800 алба хаагчийг багтаасан дотоод группэд 225 төрлийн мэдээ, мэдээлэл, 12 шууд нэвтрүүлэг хийж, 15 видео мэдээлэл оруулж, аяны үйл ажиллагааг идэвхжүүлсэн.

Алба хаагчдын сургалтад зориулж 878 хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, 1015 аудио, видео бичлэг, богино хэмжээний кино бүтээж, 6029 ширхэг гарын авлага, тараах материал, бодлого, аргачлал хэвлүүлэн тарааж, сургалтад нийт 38.5 сая төгрөг зарцуулсан.

**1.2.Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:** Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний цагдаагийн газраас зохион байгуулсан “Цагдаагийн байгууллагуудын хамтын ажиллагаа” дээд хэмжээний чуулга уулзалт, Бүгд Найрамдах Турк Улсын Стамбул хотноо зохион байгуулагдсан “Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага” Интерполын Ерөнхий ассамблейн 89 дүгээр чуулганд оролцож харилцан хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын мандаттай Олон улсын энхийг дэмжих ажиллагаанд Зэвсэгт хүчний цэргийн багийн бүрэлдэхүүнд алба хаагчдыг томилон оролцуулахын зэрэгцээ Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс, Бүгд Найрамдах Судан Улсад бие даасан цагдаагийн

ажилтнаар алба хаагчдаа томилуулан ажиллуулдаг болсноор нийт 28 алба хаагч ажиллагаанд оролцож, үүргээ амжилттай гүйцэтгэж байна. Олон улсын энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан “Энхийг сахиулагч өдөрлөг”-ийн арга хэмжээнд оролцож, Батлан хамгаалахын сайдын Б/19 дүгээр тушаалаар “Африкт энхийн төлөө” дурсгалын медалиар 9 алба хаагчийг шагнаж, урамшуулсан.

Монгол Улсад Хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөний дагуу “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын гадаад хамтын ажиллагаа, цаашдын чиг хандлага” сэдэвт олон улсын зөвлөгөөнийг зохион байгуулж, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерпол, Элчин сайд, цагдаа, хууль сахиулах байгууллагын атташе зэрэг олон улсын 5 байгууллагын 90 гаруй зочин, төлөөлөгч оролцож, Монгол Улсын цагдаагийн байгууллагаас 3, гадаад улсаас 8 илтгэл хэлэлцүүлэн илтгэлийг эмхэтгэлд оруулсан.

Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурал (CICA)-ын үйл ажиллагааны хүрээнд Бүгд Найрамдах Турк Улсын Мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын академиас зохион байгуулагдсан “Гэмт хэргийн талаарх мэдээллийн дүн шинжилгээ”, “Зохион байгуулалттай гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаа ба арга зүй” сэдэвт цахим сургалтад 4, Монгол Улсын Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яамтай хамтран зохион байгуулсан “Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын танилцуулга сургалтад 3 алба хаагчийг тус тус хамруулж, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай хуулиудыг англи хэл рүү орчуулан Цагдаагийн байгууллагын цахим хаягт байршуулсан.

**1.3.Үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газарт холбогдох эрүү, иргэн, захиргааны 65 хэргийн шүүх хуралдаанд хариуцагч, нэхэмжлэгчийн төлөөлөгчөөр 104 удаа оролцсон.

“Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарах асуудлын талаар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 57 нэгжид зөвлөмж боловсруулан хүргүүлж, 166 алба хаагчид хууль зүйн зөвлөгөө, эрх зүйн туслалцаа үзүүлж тодорхой үр дүнд хүрсэн.

“Алба хаагчдын чөлөөт индэр” дотоод цахим группээр дамжуулан алба хаагч, ажилтнаас ирүүлсэн 163 мэдээлэл, санал хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж, шалтгаан нөхцөлийг арилгах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох газарт хүргүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Энэ оны байдлаар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагч, ажилтнуудаас албан үүргээ гүйцэтгэх явцдаа зөрчлийн шинжтэй 9 үйлдэлд 9 алба хаагч, гэмт хэргийн шинжтэй 171 үйлдэлд 187 алба хаагч тус тус өртөж хохирсон бөгөөд алба хаагчидтай утсаар болон биечлэн уулзах, болсон үйл явдлын талаарх нөхцөл байдлыг тухай бүр тодруулах, хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, даатгалын байгууллагаас гэнэтийн ослын даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр олгуулах ажлыг зохион байгуулах талаар зөвлөмж өгч ажилласнаар 4 алба хаагчид 4.7 сая, нас барсан 1 алба хаагчийн ар гэрт 16.0 сая төгрөг нийт 20.7 сая төгрөгийн нөхөн төлбөрийг даатгалын байгууллагаас олгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шинжилгээний тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон дагалдан гарах зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ зэрэг 45 хууль, эрх зүйн 85 актын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Хууль зүйн байнгын хорооны Ажлын хэсгийн хуралдаанд оролцож, санал боловсруулан ажилласан.

Гадаад улстай байгуулах хэлэлцээрийн 4, хамтран ажиллах санамж бичгийн 11, төрийн болон бусад байгууллагатай хамтран ажиллах 24, ажил гүйцэтгэх 28, даатгалын 4, түрээсийн 2 гэрээний төслийг тус тус хянаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын батлан гаргасан 45 хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичгийн талаарх мэдээллийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдад хүргүүлж, мэдээллээр хангасан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хууль тогтоомжоор боловсруулсан гарын авлага, мэдээлэл 6, эрх зүйн акт /Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 1, Засгийн газрын тогтоол 23, сайдын тушаал 13, бусад байгууллагын даргын 4 тушаал /Цагдаагийн ерөнхий газрын даргын 34 тушаал/-ын талаарх мэдээллийг тухай бүр хүргүүлж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай Засгийн газрын 40 тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дангаар болон хамтран баталсан 69, Цагдаагийн ерөнхий газрын даргын дангаар болон хамтран баталсан 52, Улсын Ерөнхий прокурорын 19 тушаалд баяжилт хийж, тухай бүр цагдаагийн байгууллагын [www.police.gov.mn](http://www.police.gov.mn), [www.system.police.gov](http://www.system.police.gov) цахим хуудсанд байршуулсан.

**1.4. Хүний нөөцийн чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 1561, Тэргүүн дэд, Дэд, Захиргааны удирдлагын газрын даргын 88 тушаалаар давхардсан тоогоор 12754 алба хаагчийн хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр бүтцийн өөрчлөлтөөр 476, шилжүүлэн буюу зохицуулан томилсон 984, цагдаагаас офицерын бүрэлдэхүүнд 546, нөөцөөс офицер, дадлагажих ажилтнаар 67, хүүхэд асрах чөлөө цуцалсан 46, Дотоод хэргийн их сургууль, Орос, Туркийн цагдаагийн академи төгссөн 180, нийт албан тушаал дэвшүүлэн томилсон 550 ба үүнээс газар, хэлтсийн даргаар 62, шинээр тасаг, хэсгийн даргаар 75, чиглэлийн ахлахаар 78, ахлахаар 279, албан тушаалд жинхлэн томилсон 56, шууд томилсон 2, нөөцөөс томилсон 37, төрийн өөр байгууллагаас шилжүүлэн буюу сэлгэн томилсон 13, шүүхийн шийдвэрээр 1, албан тушаал буурсан 11, Тусгай ажиллагааны газрын болон бусад нэгжид цагдаагаар 56 алба хаагчийг тус тус томилсон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2 дахь заалтаар 40, эрүүл мэндээр 1, сургуульд суралцуулахаар 19, өөрийн хүсэлтээр 122, тэтгэвэрт 178, томилсон албан тушаалд очоогүй 2, хүүхэд асрах чөлөө олгосон 75, цагдаагийн байгууллагын ёс зүйг ноцтой зөрчиж халагдсан 11, сахилгын шийтгэлээр 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр 46 алба хаагчийг тус тус албанаас чөлөөлж, 11 алба хаагчийг данс бүртгэлээс хасаж, 1 алба хаагчийн хүүхэд асрах чөлөөг цуцалж, 4 алба хаагчийн албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлж, 11 алба хаагчаар албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж, 16 алба хаагчийг үүрэг гүйцэтгэгчээр томилсон.

Харьяа нэгжээс цагдаагийн цол олгуулахаар ирүүлсэн 2109 алба хаагчийн материалыг хүлээн авч болзол шаардлага хангасан 2025, Дотоодын цэргийн штабаас цол олгуулахаар 57 алба хаагчийн материал ирүүлснээс болзол хангасан 55 алба хаагчид цол олгох тухай тушаалын төслийг боловсруулан удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлээ.

Мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс цагдаагийн цол олгуулах 60, хураалгахаар ирүүлсэн 9, хадгалуулах 2, Дотоод хэргийн их сургуулиас цагдаагийн цол олгуулах 74, хадгалуулах 12, хураалгахаар ирүүлсэн 4 алба хаагчийн тушаалын төслийг тус тус боловсруулж, удирдлагад танилцуулан шийдвэрлүүлсэн.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад нэмэгдүүлсэн 650 орон тооны талаар харьяа албад, газар, хэлтэс, төвөөс авсан саналын дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар хүүхдийн байцаагчийн 103, хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаагийн 281, эргүүл, жижүүрийн 70, зохицуулагч 50, эрүүгийн мөрдөгч 10, мөрдөгч 17, сэтгэл зүйч 20, холбоо мэдээллийн инженер 20, дотоодын цэрэгт 79 орон тоог нэмэгдүүлж, нэгжүүдэд мэдээлэл хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн болон Захиргааны удирдлагын газрын даргын нийт 1521 тушаалын дагуу алба хаагчдын шилжилт, хөдөлгөөн, сул орон тооны товчоог гарган үйл ажиллагаандаа ашиглалаа.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах талаар ирүүлсэн 134 санал, материал хүлээн авч, холбогдох ажиллагааг хийж, нийт 84 тушаалын төсөл бэлтгэж, шийдвэрлүүлсэн.

Тээврийн цагдаагийн алба, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах саналын дагуу холбогдох ажиллагааг хийж, бүтэц, орон тоо, албан тушаал, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн батлуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас ирүүлсэн саналын дагуу шинээр нэмэгдсэн болон өөрчлөлт оруулах саналтай 207 албан тушаалын тодорхойлолтын төсөл боловсруулж, жагсаалт гарган удирдлагад танилцуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/102, А/257 дугаар тушаалуудаар нийт 186 албан тушаалын тодорхойлолтыг батлуулж, холбогдох нэгжүүдэд хүргүүлж ажилласан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Төрийн одон, медаль, цэргийн дээд цолоор шагнуулахаар нэр дэвшсэн 522, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар шагнуулахаар нэр дэвшсэн 772, Цагдаагийн ерөнхий газрын шагналаар шагнуулахаар нэр дэвшсэн 3257, нийт 4551 алба хаагчийн материалыг хүлээн авч, судлан 431 алба хаагч, ажилтныг төрийн одон медаль, 734 алба хаагч, ахмад ажилтныг Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар шагнуулах саналтай материалыг хүргүүлснээс Монгол Улсын Хөдөлмөрийн баатар 1, Гавьяат хуульч 3, Үйлчилгээний гавьяат ажилтан 3 төрж, Цэргийн дээд хошууч генерал, бригадын генерал цолоор тус бүр 1, төрийн одон, медалиар 60, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар 721 алба хаагч, ажилтан, ахмад ажилтан шагнагдсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Цагдаагийн байгууллагын хүндэт ажилтан тэмдэг 1, Цагдаагийн гавьяа тэмдгээр 395, Дотоодын цэргийн алдар тэмдгээр 8, Цагдаагийн төлөө тэмдгээр 16, Монгол цагдаа тэмдгээр 195, Хүндэт жуухаар 505, Албаны төлөө зэргийн тэмдгээр 1326, Эрүүгийн цагдаагийн хүндэт ажилтан тэмдгээр 17, Спортын алдар тэмдгээр 29, нийт 2492 алба хаагч, иргэнийг шагнаж урамшууллаа.

Энэ онд 3273 ажилтан, алба хаагч шагнагдсан нь нийт алба хаагчдын 29.7 хувийг эзэлж байна.

**1.5. Улсын онц чухал объектын харуул, хамгаалалтын чиглэлээр:** Улсын онц чухал объектын хамгаалалтыг зохион байгуулж, объектуудад давхардсан тоогоор 1621944 ажилчин, 160575 иргэн, 747 гадаадын иргэн, 409301 тээврийн хэрэгслийг тус тус шалган нэвтрүүлж, 804411 хөдөлгөөнийг бүртгэн хяналт тавьж, 20934 тонн 361.3 кг тэсэрч дэлбэрэх бодис, 12041344 метр, 6576703 ширхэг тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй байдлыг ханган ажилласан.

Тайширын усан цахилгаан станц, Тавантолгой нүүрсний уурхай, Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн Дамбадаржаагийн усан санг хамгаалалтад хүлээн авсан.

**1.6. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газраас 216.184 дагагч бүхий албан ёсны цахим хуудсаар дамжуулан Авлигатай тэмцэх газрын олон нийтийн төв болон Авлигатай тэмцэх газрын албан ёсны пэйж хуудаснаас мэдээ, мэдээллийг эх сурвалжийн хамт хуулбарлан авч, иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын пэйж хуудсанд авлига, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх утга агуулга бүхий постер 24, мэдээ, мэдээлэл 18, видео шторк 11 нийт 53 мэдээлэл байршуулсан нь 1.242.153 хүнд хүрч, 403 удаа бусадтай хуваалцсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасны дагуу shilendans.gov.mn сайт болон байгууллагын цахим хуудсанд, “Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх /давхардсан тоогоор/ нийт 44 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилга, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.police.gov.mn](http://www.police.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)-нд болон өдөр тутмын сонин хэвлэлд холбогдох хууль, журмын дагуу тус тус байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын Авлигын эсрэг эрх зүйн орчин, төрийн байгууллагуудын авлигатай тэмцэх үйл ажиллагаанд мониторинг хийсэн зөвлөмжийн цагдаагийн байгууллагад хамаарах 6 зорилт, 25 ажил арга, хэмжээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар 92.16 хувиар үнэлж, энэ оны 3/422 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газраас 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/696 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 6 зорилт, 51 заалтын хүрээнд боловсруулан батлуулж, хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар 96.7 хувиар дүгнэж, Авлигатай тэмцэх газарт 01/1018 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын “Авлигын төсөөллийн шалгуур үзүүлэлт /индекс/-ийг бууруулах, хангах, эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө”-ний цагдаагийн байгууллагад хамааралтай заалтын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, үр дүнг тооцон үнэлэх үүрэг бүхий ажлын хэсгийг А/236 дугаар тушаалаар байгуулж, 7 бүлэг 30 заалттай төлөвлөгөө гарган хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

**1.7.Эрсдэлийн үнэлгээний чиглэлээр:** Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх /код-137/ журам”-ын 137.4.4-т заасны дагуу эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан нэгжүүдийг өөрийн байгууллагын түвшинд эрсдэлийн удирдлагыг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлсэн байдлыг харгалзан 8 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийхэд 8 оноотой 27 нэгж, 8-аас доош оноотой 21 нэгж байна.

Цаашид 8-аас доош оноотой нэгжүүдийн хувьд дотоод хяналтын орчныг сайжруулах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг идэвхжүүлэх, “Сайжруулалт шаардлагатай” гэж дүгнэхээр байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын хэмжээнд эрсдэлээ үнэлсэн байгууллагуудын эрсдэлийн үнэлгээний дүнг үндэслэн цагдаагийн байгууллагын 2021 оны эрсдэлийн үнэлгээг хийж, Цагдаагийн байгууллагын удирдлагад танилцуулах шаардлагатай их эрсдэлтэй буюу 20-25 оноотой төсөв санхүүгийн 5, үйл ажиллагааны 36, нийцлийн 2, гадаад хүчин зүйлийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн 8, нийт 51 эрсдэлийг байгууллагад үзүүлэх нөлөөллийн түвшин, давтагдах магадлал, чанарын түвшнийг харгалзан нэгтгэлээ.

**1.9.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар:** Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн удирдах албан тушаалтанд 2021 онд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 16542 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4963 нэгжээр буюу 42.9 хувиар өсөж нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 237 буюу 1.4 хувь нь санал, 16035 буюу 96.9 хувь нь өргөдөл, 270 буюу 1.6 хувь нь гомдол байна.

Нийт санал, өргөдөл, гомдлын 1300 буюу 7.9 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 285 буюу 1.7 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 2719 буюу 16.4 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 2131 буюу 12.9 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 597 буюу 3.6 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 9510 буюу 57.5 хувь нь бусад өргөдөл гомдол байна. . Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 16382 буюу 99.0 хувийг шийдвэрлэж, 160 буюу 1.0 хувь нь ажиллагаанд байна.

Мөн хугацаанд иргэдээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 189 санал хүсэлт, өргөдөл гомдол, талархал, ирүүлсний 188 буюу 99.5 хувийг шийдвэрлэжээ.

### **Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтийн талаар**

**2.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага /ИОМ/-тай хамтран Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл “Хүн худалдаалах” гэмт хэрэгт өртөж хохирсон охид, эмэгтэйчүүдийг олж тогтоох, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, дээрх гэмт хэргийн хор уршгийг олон нийтэд таниулах зорилгоор “Мөрөөдлийн шүхэр” аян, арга хэмжээг зохион байгуулсан.

Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлийн 2020 оны судалгааны тайланг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүйсийн тэгш эрхийн төв, Эмэгтэйчүүдийн хүний эрхийн хүрээлэн, төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр цагдаагийн байгууллагын объектын судалгаанд 187 аж ахуйн нэгж, субъектийн судалгаанд 354 биеэ үнэлэгч, зохион байгуулагч, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож болзошгүй этгээдийн талаарх мэдээллийг оруулж, 13 төрлийн 39.000 ширхэг тараах материалыг хэвлүүлэн иргэд, аж ахуйн нэгж байгууллагад тараасан.

Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд “Ирээдүйгээ-хамгаалъя”, “Сэрэмжилье-Болгоомжилъя”, “Байна уу байна” аян, нэгдсэн 22, тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд 756, хэсэгчилсэн 1496 нийт 2274 ажил, арга хэмжээг зохион байгуулж, мэдээллийг нийт 12 телевиз, 24 сайт, 8 радиогоор тогтмол иргэд, олон нийтэд хүргэсэн.

Үүрэн холбооны оператор байгууллагуудтай хамтран 2.5 сая иргэний гар утсанд “Таны дуу хоолой байгалийг хамгаалж чадна”, “Байгаль дэлхийгээ хайрлаж хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлье” “Хамгаалах бүсээ зүүж, хурдаа тохируулъя, хайртай гэр бүлийн тань амь нас, эрүүл мэнд зөвхөн танаас шалтгаална”, “Ирээдүйгээ хамгаалъя ЦЕГ” гэсэн мессеж илгээж ажилласан.

Шүүх, прокурор, удирдах ажилтнуудтай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсүүдийн эрүүлжүүлэх байранд эрүүлжүүлэгдсэн, архины хамааралтай 4480 иргэн, 36 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 2085 иргэнийг 3 удаагийн цахим зөвлөгөөн, 22 удаагийн уулзалт хэлэлцүүлэгт хамруулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 110, орчин цагийн Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойг угтаж байгууллага, хамт олноо сурталчлах зорилгоор цагдаа, дотоодын цэргийн ахмад, дунд, залуу үеийн төлөөлөл “Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан” цол тэмдэгтэй уран бүтээлч алба хаагчдыг оролцуулсан “Эх орны тангарагтай андууд-2” онлайн тоглолтыг Check.mn сайттай хамтран зохион байгуулсан.

Гэмт хэргийн хор уршиг, урьдчилан сэргийлэх арга зам, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэргийг бууруулах, таслан зогсоох чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг таниулах зорилгоор 15 телевиз, өдөр тутмын 3 сонин, 25 сайт, 12 фм радиогоор тус тус телевизийн 5 хэлэлцүүлэг, 2 зорилтот нэвтрүүлэг, 19 мэдээ сурвалжилга, 23 ярилцлага өгч, 86 мэдээ, сурвалжилга бэлтгэн контентыг youtube, фэйсбүүкт оруулсныг 1.103.105 хүн үзэж, 12.156 хүн бусадтай хуваалцаж, 13.165 хүнд таалагдсан байна.

**2.2.Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:** Тус алба хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, эрэн сурвалжлагдаж байгаа сэрдэгдсэн болон оргодол этгээдүүдийг олж тогтоох зорилгоор “Шийдвэрлэлт”, “Шүүхээс даалгасан бусад хүн”, “Тоглоом”, “Шоо”, “Яргуй”, “Урамшуулал”, “Сүлжээ” “Сураггүй алга болсон хүн” “Илрүүлэлт оргодол”, “Мал мах” зэрэг 13 удаагийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг улс, нийслэлийн хэмжээнд зохион явуулж, үр дүнг тооцсон.

Эрүүгийн цагдаагийн албаны хэмжээнд 4278 холбогдогчтой, 83.2 тэрбум төгрөгийн хохиролтой, хэрэг бүртгэлтийн 14357 хэргийг илрүүлэн мөрдөн байцаалтад шилжүүлсэн бөгөөд нийт хэргийн 2431 буюу 17 хувийг хүнд, 11926 буюу 83 хувийг хөнгөн хэрэг эзэлж байна.

Илрүүлсэн хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5854 нэгжээр буюу 22.0 хувь, гэмт хэргийн гаралт 15282 нэгжээр буюу 33.0 хувиар тус тус өсөж, илрүүлэлт 46.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эрэн сурвалжлах АСАП санд 2021 онд хүн, мал амьтан, эд зүйлийн 26605 мэдээллийг бүртгэн зарлан мэдээлснээс 20637 хүн, мал амьтан, эд зүйлийг олж тогтоон, үлдэгдэл 5968, илрүүлэлт 77.5 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.9 хувиар өссөн.

Үүнээс шүүхээс даалгасан нийт 4929 хүний мэдээллийг бүртгэж зарласнаас 3716 хүнийг олж тогтоон, эрэн сурвалжлалтыг зогсоож, илрүүлэлт 75.3 хувьтай байна.

**2.3.Экологийн цагдаагийн албаны чиглэлээр:** Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр Монголын байгаль орчны иргэний зөвлөл, Лондоны амьтан судлалын нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран ажиллах “Санамж бичиг”-ийн хугацааг сунган ажиллаж байна.

Бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Байгаль эн тэргүүнд” төслийг хэрэгжүүлсэн нь Нийгмийн Ардчилал Монголын залуучуудын холбооноос зохион байгуулдаг “Алтан сарнай” наадамд “Нийгмийн эерэг нөлөөллийн шилдэг төсөл”-өөр шалгарсан.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгаль экологид учирсан хохирлыг бууруулах чиглэлээр “Таны дуу хоолой байгалийг хамгаалж чадна” уриа дор “Ногоон дуу хоолой”, биологийн олон янз байдлыг хамгаалах зорилгоор “Зэрлэг амьтдаа хайрлая-1, 2, 3”, загасыг үржлийн үед нь хамгаалах, өсгөн үржүүлэх зорилгоор “Үржлийн үед нь барихгүй”, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Ногоон дуу хоолой”, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Алдвал галдана” зэрэг 7 ухуулга, нөлөөллийн аяныг тус тус зохион байгуулснаар энэ төрлийн гэмт хэрэг 40 буюу 6.5 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр 21 аймагт 155 удаагийн хяналт шалгалтаар давхардсан тоогоор 90 алба хаагч 260 хоног 61.985 километр зам туулан хяналт шалгалтаар ажиллан нийт 299 холбогдогчтой, 1.786.210.867 төгрөгийн хохиролтой 118 гэмт хэргийг илрүүлсэн.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, байгаль экологид учирсан хохирлыг бууруулах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг 5 удаа тус тус зохион байгуулсан.

Орон нутаг дахь мэргэжлийн хяналтын байцаагч, байгаль орчны мэргэжилтэн, экологийн асуудал хариуцсан 420 алба хаагч, ажилтны хүн хүчтэйгээр уул уурхайн олборлолтын улмаас 7171.6 га газар эвдэгдэж орхигдсоныг тогтоож, орон нутгийн төсвийн хөрөнгөөр болон дүйцүүлэн хамгаалах байдлаар 758.1 га, голын сав бүхий газарт хамаарах нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулдаг 7 аж, ахуйн нэгжээр 20.7 га талбайд техникийн, 3.8 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийлгэсэн.

Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох зорилгоор ууланд нуусан 124 техник, хэрэгслийг илрүүлэн бүртгэлжүүлж, 34 техник, хэрэгслийг талбайгаас гарган, хөдлөх боломжгүй эвдэрсэн экскаватор 23, ковш 10, бульдозер 1, алт угаах төхөөрөмж 16, ачааны автомашин 3, бусад 4 нийт 57 техник хэрэгслийг буулгаж, 797.727.661 төгрөгийн хохирлоос 268.071.524 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 652.156.148 төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн.

**2.4.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссын хэрэгжилтийг хангах, иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах, хорио цээрийн дэглэм сахиулах үүргийг хэрэгжүүлж явган эргүүлд 297, шинжилгээний цэгт 18, вакцины хамгаалалтад 25, хяналтын цэгт 22, замын хяналтад 59, угтах үйлчилгээнд 7, камерын хяналтад 7, хамтарсан шалгалтад 2 нийт 437 олон нийтийн цагдаа ажиллаж, 79.779 аж ахуйн нэгж, байгууллага, 424.446 иргэнд хууль, тогтоомжийг тайлбарлан таниулж, ухуулга сурталчилгаа хийн, нийтийн хэв журам хамгаалах талаар хууль сахиулах байгууллага болон бусад хуулийн этгээдээс зохион байгуулсан 5.215 арга хэмжээнд оролцож, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 33.366 аж ахуйн нэгжид мэдэгдэл, шаардлага хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Засгийн газрын 2018 оны 62, 2020 оны 189 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр агаарын чанарыг сайжруулах бүс рүү 73.3 тонн түүхий нүүрс зөвшөөрөлгүй тээвэрлэсэн 29 үйлдэл, тусгай зөвшөөрөлгүй хагас боловсруулсан нүүрс хэрэглэсэн 68 аж ахуйн нэгжийг тус тус илрүүлж, холбогдох байгууллагад шилжүүлэн, хуулийн дагуу хариуцлага тооцуулсан.

Шалган нэвтрүүлэх 6 хяналтын цэгийн хяналт шалгалтаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн 323, цагдаагийн байгууллагын АСАП санд эрэн сурвалжлагдсан 31, гарал үүслийн бичиггүй мал, мах 193, галт зэвсэг 10, гамшгаас хамгаалах тухай хууль зөрчсөн 22 нийт 835 гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэн харьяаллын дагуу шилжүүлсэн.

Агаарын чанарыг сайжруулах бүсэд тавих хяналтыг сайжруулах зорилгоор “Хяналт-1” арга хэмжээг зохион байгуулж, Нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт цагдаагийн байгууллагаас давхардсан тоогоор 1161, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас 15, Онцгой байдлын газраас 84, хороодын хэсгийн ахлагч, урамшуулалт эргүүл 1888, “Таван толгой түлш” ХК-ийн хяналтын 1061 нийт 4209 алба хаагч, ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллаж, 135.299 айл өрх, 1705 аж, ахуйн нэгж, байгууллагыг шалгаж, 226.016 иргэнд яриа таниулга хийн, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн ажиллалаа.

**Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар:** Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч нарт 5 удаа цахимаар мэдээлэл хийн, үүрэг, ажлын чиглэл өгч, биелэлт, үр дүнг тооцон ажилласан.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын штаб, төв, орон нутаг дахь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор



Тэргүүн дэд, Дэд даргаар ахлуулсан зөвлөлийн гишүүдийг хуваарьт оруулан 24 цагаар үүрэг гүйцэтгүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 27, 91, 104 дүгээр тогтоолоор коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед хорио цээрийн дэглэм сахиулах чиглэлээр холбогдох төлөвлөгөө, зураглал, хуваарийн дагуу 3695 эргүүл, хяналтын цэгт нэмэгдлээр яам, агентлаг, төрийн захиргааны байгууллагын 6231 ажилтан, албан хаагчийг 3 ээлжээр хуваарилан томилгоожуулан ажиллуулсан.

Нийслэл хотод орох, гарах хөдөлгөөнд хяналт тавих 7 постоос Эмээлт, Гүнтийн давааны 2 постод 3, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Цэргийн төв эмнэлэг, Амар, Наранбулаг, Парк, Дрийм, Корпорейт, Кентавор, Тоёоко-Инн, Туушин зочид буудлууд, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Жаргалант сургалтын нэгдсэн төв зэрэг тусгаарлан ажиглах байрууд, Замын хөдөлгөөний удирдлагын төвийн 48, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 63, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн гудамж, талбайн телехяналтын камерын дүрсийг Шуурхай удирдлагын штабт холбож, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, коронавируст халдварын цар тахлаас хүн амыг урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн тушаалаар нийт бие бүрэлдэхүүнийг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 2, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт 3 удаа шилжүүлэн хорио цээрийн дэглэм сахиулах хамгаалалт, зохицуулалтад давхардсан тоогоор 386.056, гадаад улсаас Монгол Улсын иргэдийг татан авах 354 удаагийн тусгай үүргийн нислэг, хилийн боомтоор 77 удаагийн татан авах, тусгаарлах үеийн хамгаалалтад давхардсан тоогоор 14.455, вакцины 47 удаагийн татан авалтаар 7.828.690 хүн/тунг татан авч, хүргэх үеийн хамгаалалт, зохицуулалтад 341 алба хаагч тус тус үүрэг гүйцэтгэсэн.

Олон нийтийн сүлжээнд цар тахлын талаар илт худал мэдээлэл түгээж, Эрүүгийн /13.14 дүгээр зүйл Худал мэдээлэл тараах/ болон Зөрчлийн тухай хууль /5.13 дугаар зүйл Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих/ зөрчсөн 113 үйлдлийг олж тогтоон, цахим хаягийг хаалгах хүсэлтийг албан бичгээр Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлснээс 82 хаягийг хаасан. Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлсэн, илт худал мэдээлэл түгээсэн 75 иргэнд 21.0 сая төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж, 3 иргэнийг захиргааны журмаар баривчлуулсан.

Баталгаат болон баталгаат бус замаар хорио цээрийн дэглэм зөрчин зорчиж байгаа үйлдлийг таслан зогсоох, хяналт шалгалтыг эрчимжүүлэх зорилгоор 2021 онд нийслэл хот руу нэвтрэх чиглэлд 442122 тээврийн хэрэгсэл, 1080613 иргэн, гарах чиглэлд 631896 тээврийн хэрэгсэл, 1375740 иргэн, нийт давхардсан тоогоор 1074018 тээврийн хэрэгсэл, 2456353 иргэнийг тус тус шалган нэвтрүүлж, хамгаалалт, зохицуулалтад хоногт 544 алба хаагч, 71 автомашинтай үүрэг гүйцэтгэж байна.

Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх, аливаа эрсдэлийг бууруулах зорилгоор нийслэлийн хэмжээнд 610 орон сууцны 1484 орц, хонгил, 51 барилга байгууламж, 6 хүнсний зах, худалдааны төв, 46 дулааны худаг, хоёрдогч түүхий эд авах цэгт үзлэг шалгалт хийж, гэр оронгүй, тэнэмэл байдлаар амьдардаг 107 хүнийг олж тогтоон, Нийгмийн хамгааллын тусгай төвд 77, Шинэ амьдрал ялагч, Өлзийт асар, Тэрэм-Уул, Титэм констракшн зэрэг 4 төрийн бус байгууллагад 30 хүнийг хүлээлгэн өгч, коронавируст халдварын PCR шинжилгээнд хамруулсан.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний газруудад холбогдох журам, тусгай нөхцөл шаардлага, Хариуцлагын гэрээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Худалдаа, үйлчилгээний газруудад хийх хамтарсан хяналт шалгалтын удирдамж”-ийг баталж, энэ оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс хойших хугацаанд Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтарсан хяналт, шалгалтыг зохион байгуулж, цагдаагийн байгууллагаас давхардсан тоогоор 12131, Мэргэжлийн хяналтын газраас 9222, Нийслэлийн захирагчийн албанаас 10599, нийт давхардсан тоогоор 31952 алба хаагч үүрэг гүйцэтгэж, 77005 иргэн, хуулийн этгээдийг шалгаж, хариуцлагын гэрээгүй үйл ажиллагаа явуулсан 341, Коронавируст халдвар /КОВИД-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам зөрчсөн 10583, тусгай нөхцөл шаардлага зөрчсөн 1616, цаг хэтрүүлэн ажилласан 390, бусад 1085 нийт 14015 зөрчил илрүүлж, 8893 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 1921 зөрчилд зөрчил шалган

шийдвэрлэх ажиллагаа явуулж нийт 262 хуулийн этгээд, 1549 хүнийг 352.900.000 төгрөгөөр торгож, 23 хүнийг шүүхээр баривчлуулж, 146 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал явуулснаас 42 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, зөрчлийн хэрэг бүртгэлтийн 101 ажиллагаа явуулж шийдвэрлүүлж ажиллалаа.

**Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/90 дүгээр тушаалаар баталсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Прокурорын шаардлагыг бүртгэх /код 718/ журам”, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2021 оны 3/255 дугаар албан бичгээр ирүүлсэн үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудын зөрчил шалгах, хэрэг бүртгэлтийн ажиллагаанд гарч буй зөрчил, дутагдлын талаар Прокурорын байгууллагаас ирүүлсэн шаардлагад улирал бүр дүн шинжилгээ хийхэд нийт 63 шаардлагыг давхардсан тоогоор 367 алба хаагчид холбогдуулан ирүүлснээс 41 буюу 65.0 хувь орон нутаг дахь цагдаагийн байгууллага, 22 буюу 34.9 хувийг нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газар, хэлтсийн зөрчил шалгах эрх бүхий алба хаагчдын гаргасан алдаа, дутагдал, зөрчлийг арилгуулахаар ирүүлсэн байна.

Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад шаардлага 8 нэгжээр өссөн харин холбогдсон алба хаагч 25 нэгжээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Зөрчлийн үлдэгдлээр шалгагдаж байгаа зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Зөрчлийн хэргийн шийдвэрлэлт-2021” нэгдсэн арга хэмжээг энэ оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс нэг сарын хугацаатай зохион байгуулж, хугацаа сунгасан 2131 хэргээс 1470 буюу 68 хувийг шийдвэрлээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуультай холбогдуулан цагдаагийн байгууллагад хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн нийт 92 гомдол, мэдээлэл хүлээн авснаас хүний улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 79 бусад гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 13 гомдол, мэдээллийг хүлээн авч, 71 гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн болон зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 8 гомдол, мэдээллийг Тагнуулын ерөнхий газар болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт харьяаллын дагуу шилжүүлж, 8 хүнийг 40.8 сая төгрөгөөр торгож шийдвэрлэсэн.

**2.5.Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр:** Нийслэлийн хэмжээнд явган хүний замыг нарийсгаж, явган зорчигч чөлөөтэй зорчих боломжгүй болгосон, тээврийн хэрэгслийн жолоочийн үзэгдэх орчинг хязгаарлаж зам тээврийн осол, хэрэг гарах нөхцөлийг бүрдүүлсэн хашаа, объектын судалгааг гаргаж, зөрчлийг арилгуулах талаар Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт инженерчлэлийн газруудад албан бичгээр мэдээлэл хүргүүлж, уг ажлын хүрээнд “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар”- аас Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байрлуулсан өнгө үзэмжгүй, явган хүний хөдөлгөөнд саад учруулж буй 48 ширхэг хаяг, мэдээллийн байгууламжуудыг албадан буулгах ажил хийгдэж, үзэгдэх орчныг сайжруулж, явган зорчигч аюул, саадгүй зорчих боломжийг бүрдүүлсэн.

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Беларусь, Бүгд Найрамдах Франц улс болон Европын холбооноос Монгол Улсад суух элчин сайд нар Монгол Улсын Ерөнхийлөгчид итгэмжит жуух бичиг өргөн барих ёслолын ажиллагаа, ОХУ-ын “Газфром” НХН-ийн удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов, АНУ-ын Төрийн департаментын туслах нарийн бичгийн дарга Венди Шерман, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Гадаад харилцааны сайд Др. Ражкумар Ранжан Сингх тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол Улсад хийх ажлын айлчлал, Монгол цэргийн бахархлын өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой болон Төрийн туг цэнгүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааны үеийн замын хөдөлгөөний хамгаалалт, зохицуулалтыг зохион байгуулсан.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийн товч мэдээлэл, шалтгаан, нөхцөл, хор уршгийг таниулах, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сэрэмжлүүлэг, ноцтой зам тээврийн осол гэмтэл, долоо хоног, амралтын өдрүүдийн нөхцөл байдал, замын байгууламжийн талаар 256 төрлийн мэдээ, мэдээлэл бэлтгэн, 28 телевизэд давхардсан тоогоор 558, фм радиод 242, албаны болон бусад цахим 56 сайтад 310 удаа, 3 төрлийн сонинд 5 төрлийн мэдээллийг тус тус өгч, иргэд, олон нийтэд түгээсэн.

Орон нутгийн авто замд үйлдэгддэг зам тээврийн гэмт хэрэг, ослыг бууруулах, урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, мэдлэг, мэдээлэл олгох, аюулгүй байдлыг хангах зорилгоор “Оюу толгой” ХХК-тай хамтран “Ирээдүйгээ

хамгаалъя” уриатай “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж байна.

**2.6.Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны чиглэлээр:** Цагдаагийн байгууллагын гомдол, мэдээллийн болон гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санд 2.178.426 нэгж мэдээлэл бүртгэгдсэн.

Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг судлан үзэх эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас сүлжээгээр ирүүлсэн 701 албан бичгийн дагуу 34.162 хүн, 104 хуулийн этгээд, “Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас”-аар 10.606 хүнийг тус тус шалган хариу өгч, иргэдийн хүсэлтээр 10.363 ширхэг тодорхойлолт олгон, ялтны хувийн хэргээс хуулбар авах тухай 1.537 албан бичгээр 1.579 хүнд холбогдох 2.364 хувийн хэргээс 28.251 хуудас материалыг хуулбарлаж өгсөн.

**Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл:** 2021 оны байдлаар цагдаагийн байгууллагад нийт 267.221 гомдол, мэдээлэл бүртгэгдэн шалгагдсаны 71.495 буюу 26.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 195.726 буюу 73.2 хувь нь зөрчлийн шинжтэй байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 6864 буюу 2.6, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 3948 буюу 5.8, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 2916 буюу 1.5 хувиар тус тус өссөн. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 23139 буюу 32.4 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 44165 буюу 61.8 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзан, 752 буюу 1.1 хувийг нь харьяаллын дагуу шилжүүлсэн. Шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 10757 буюу 15.8 хувийг 5 хоногт, 55997 буюу 82.3 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн.

Улсын хэмжээнд нийт 25429 гэмт хэрэг бүртгэгдсэний 16534 буюу 65.0 хувь нь нийслэлд, 8880 буюу 34.9 хувь нь орон нутагт, 15 буюу 0.1 хувь нь бусад газарт /хилийн чанадад/ бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад гэмт хэрэг 2365 буюу 10.3, нийслэлийн хэмжээнд 1901 буюу 13.0, орон нутагт 460 буюу 5.5, бусад газар /хилийн чанадад/-т 4 буюу 36.4 хувиар тус тус өссөн.

Хулгайлах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 10.2, дээрэмдэх гэмт хэрэг 9.4, мал хулгайлах гэмт хэрэг 29.3 хувиар тус тус буурч, залилах гэмт хэрэг 53.6, хүчиндэх гэмт хэрэг 9.5, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3.4, хүүхдийн эсрэг гэмт хэрэг 82.4, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3.1 хувиар тус тус өссөн.

Улсын хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 52.7, нийслэлд 50.3, орон нутагт 58.9 хувь байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 0.8, нийслэл хотод 2.0 нэгжээр тус тус өсөж, орон нутагт 0.3 нэгжээр буурчээ.

Гэмт хэргийн улмаас 59 хуулийн этгээд, 24994 иргэн хохирсноос 683 хүн нас барж, 8299 хүн гэмтсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 13 буюу 1.9, гэмтсэн хүн 124 буюу 1.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

**Мэдээлэл хүлээн авах, шуурхай удирдлагын чиглэлээр:** Улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн 586.728 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн 24.061, зам тээврийн осол, хэргийн 100.934, зөрчлийн 405.393, сураггүй алга болсон хүн/хүүхэд 3380, олдсон хүн/хүүхэд 1935, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн 48.170, бусад 2855 бүртгэгдсэн ба үүнээс: гадаадын иргэнтэй холбоотой 279, архидан согтуурсантай холбоотой 144.404, цагдаагийн алба хаагчтай холбоотой 1057, хар тамхи, мансууруулах бодистой холбоотой 181 мэдээ, мэдээлэл бүртгэгджээ.

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалах, холбогдох байгууллагад холбон зуучлах, дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхдийн тусламжийн 108 дугаараас цагдаагийн байгууллагын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 102 тусгай дугаарт ирүүлсэн 2159 дуудлагыг хүлээн авч, хамтран ажилласан.

Орон нутаг болон дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсээс зарлуулахаар ирүүлсэн сураггүй алга болсон болон олдсон хүн/хүүхэд/, хулгайд алдагдсан тээврийн хэрэгсэл, эд зүйлс, мал зэрэг нийт 239 мэдээллийг цагдаагийн байгууллагын дотоод сүлжээгээр зарлан мэдээлсэн.

Нийслэлийн Шуурхай удирдлагын хэлтсүүдийн хооронд шилжүүлсэн нийт 6275 дуудлага, 102 тусгай дугаарын утсанд бүртгэгдсэн хулгайн 3858, хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн 47.946 дуудлагын шийдвэрлэлт, очсон хугацаанд хяналт тавьж, хулгайлах гэмт хэргийн дуудлага өгсөн 3557, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага өгсөн 17.686,

сураггүй алга болсон гэж мэдээлэл өгсөн 3481, нийт 24.724 иргэнтэй холбогдож, гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан.

**2.7.Архивын үйл ажиллагааны чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын дэргэдэх Нууц баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлыг 3 удаа зохион байгуулж нийт 66 байгууллагын нууцын зэрэглэлд хамаарах баримтын 91 жагсаалт, 4317 хадгаламжийн нэгж, 11093 нууц тээгчийг хянан хэлэлцсэнээс 63 байгууллагын жагсаалтыг баталгаажуулж, 3 байгууллагын баримтын бүрдэл дутуу үндэслэлээр буцааж, дахин бүрдүүлэлт хийлгэн, 54 байгууллагын 250 бүртгэл, 44 устгах хэргийн актыг хэлэлцэн баталгаажуулсан.

Хөмрөг үүсгэгч 57 байгууллагаас төрийн нууцад хамаарах 2016-2018 оны 1320 баримт, нөхөн бүрдүүлэлтийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу 34 байгууллагын байнга хадгалах 2339, боловсон хүчний 70 жил хадгалах 56, боловсон хүчний 918 хувийн хэрэг нийт 3313 баримтыг нягтлан шалгаж, дугаар олгон хадгаламжийн санд байрлуулсан.

Байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу иргэд хүлээн авах байраар 894, албан бичгээр 442, өргөдлөөр 13 захиалга авч, 1349 архивын лавлагаа, тодорхойлолт гарган олгосон бөгөөд байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 109 хөмрөгийн 111 дансны 390 хадгаламжийн нэгжийн 79064 хуудас баримтаас шүүлт хийж, 1399 хуудас баримтыг хуулбарлан баталгаажуулж олгосон.

Цаасан суурьтай баримтыг лавлагаа, мэдээлэл, уншлагын танхим, судалгаа, эрдэм шинжилгээ, нягтлан шалгалтад зориулж 238 хөмрөгийн 244 данс бүртгэлийн 1498 хадгаламжийн нэгжийн 318801 хуудас баримтыг бүртгэлийн дагуу олгож, ашиглуулсан.

Орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан Цагдаа, дотоодын цэргийн түүхэнд холбогдох нэн үнэт баримтуудыг Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс 17 хөмрөгийн 24 дансны 371 хадгаламжийн нэгжийн 14896, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын архиваас 1 хөмрөг, 75 хадгаламжийн нэгжийн 1263, Нийслэлийн архивын газраас 1 хөмрөгийн 1 дансны 33 хадгаламжийн нэгжийн 730, Тагнуулын ерөнхий газрын Тусгай архиваас 1 хөмрөгийн 311 хадгаламжийн нэгжийн 5442, нийт 22331 хуудас хуулбарлан авч, судалгааны эх сурвалж болгон “Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүхэн баримт бичгийн эмхэтгэл” /1911-2021 он/, “Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүх” /1911-2021 он/, “Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүхэн баримт бичгийн эмхэтгэл” /1911-2021 он/ номыг бүтээж хэвлүүлэн нийтийн хүртээл болгосон.

**2.8.Хэвлэл, мэдээллийн чиглэлээр:** Цагдаагийн байгууллагын албан ёсны [www.police.gov.mn](http://www.police.gov.mn) сайтад байгууллага, алба хаагч, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх аян, арга хэмжээтэй холбоотой 81 ярилцлага, цаг үе, үйл явдлын 196, видео мэдээ 29, бусад 66 нийт 372 мэдээ, мэдээллийг бэлтгэн байршуулсан нь давхардсан тоогоор 2.917.854 хүний хандалт авсан байна.

Хэвлэл, мэдээллийн төвийн фэйсбүүк цахим хуудаст цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын онцлог үйл явдал, аян арга хэмжээ, ярилцлага, мэдээ мэдээлэл 1630-ыг бэлтгэн иргэд, олон нийтэд түгээж ажилласан. Мэдээ, мэдээлэл, ярилцлага, постерыг давхардсан тоогоор 14.335.879 хүн үзэж, 550.534 хүнд таалагдаж, 29.120 удаа хуваалцаж, 13.947 удаа сэтгэгдэл үлдээж, твиттер хуудаст 107 мэдээ, мэдээллийг байршуулан ажилласан.

“Монгол төрийн цагдаа” эмхэтгэлийн 2020 оны IV, 2021 оны I, II, III улирлын дугаарыг “Адмон” ХХК-ийн хэвлэлтээс тус тус 2000 ширхэг буюу нийт 8000 ширхгийг хүлээн авч, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хуваарийн дагуу тараан олгож, 2021 оны IV улирлын сэтгүүлийг бэлтгэж байна.

Цагдаагийн төв байгууллагын үйл ажиллагаа, удирдлагаас авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг алба хаагч нарт цаг алдалгүй, түргэн шуурхай, үнэн бодитоор хүргэх, алба хаагч, ажилтнуудыг соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ болон зайн сургалт, цаг үеийн болон бодлогын ярилцлага, алба хаагчдын ажлын туршлага, цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын үйл ажиллагаанд дэмжлэг болохуйц “Албаны төлөө” сонины 2 удаагийн дугаар бэлтгэж, тус бүр 6000 хувийг хэвлүүлж, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдад хүргүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын үйл ажиллагаа, онцгой үйл хэргийг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор Бидний нэг нэвтрүүлгийг 6 удаа бэлтгэж, ахмад ажилтны алдар гавьяаг алдаршуулах зорилгоор “Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, цагдаагийн бэлтгэл ахмад Базарын Балжинням”, “Цагдаагийн бэлтгэл дэд хурандаа Б.Энх-Амгалангийн

мэргэжлийн ур чадвар гарган онц хүнд гэмт хэргүүдийг илрүүлсэн тухай”, “Хүн амины 130 гаруй хэргийг шалгаж, мэргэжлийн ур чадвар гарган илрүүлсэн цагдаагийн бэлтгэл дэд хурандаа Б.Ванданмягмар агсан”, “1966 оны Улсын Их баяр наадмыг тараасан тухай”, “Монгол Улсын баатар Д.Намнан”, “Цагдаагийн ахлагч Ц.Гомбосүрэн агсан” зэрэг 11 удаагийн 3-7 минутын “Цахим дурдатгал” видео контент, “Токио 2020” зуны олимпын XXXII наадамд оролцож буй 4 алба хаагчийн талаарх 2 ярилцлага, 2 хөрөг, 3 постер, нийт 7 мэдээ, мэдээлэл, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Та гэртээ хамгийн аюулгүй” 19 удаагийн зурагт постер, “Гэртээ байцгаая” сэдэвт 41 удаагийн видео уриалга, шторкийг тус тус бэлтгэн, иргэд, олон нийтэд түгээсэн.

Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдал, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр давхардсан тоогоор 956 хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, тодруулга мэдээллийг өгсөн.

Иргэд, олон нийтэд олон талт мэдээ, сэрэмжлүүлэг, мэдээллийг хүргэх зорилгоор “Клабхаус” апплейкшнээр дамжуулан “Хөл хорио ба гэмт хэрэг” цахим ярилцлагыг 2 удаа, байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан эерэг контент түгээх зорилгоор “Гэрлэх санал тавьсан өдрөө гэнэтхэн орхиод явсан хань минь” нэртэй 2 удаагийн захидал, “Дурсамж тэмдэглэл” “С.Нандин-Эрдэнэ охиноос ирүүлсэн захидал” зорилтот нийтлэлийг тус тус бэлтгэн түгээсэн.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ, мэдээллийг түгээх ажлын хүрээнд “Амрыг эрье” 15, 20, минутын нэвтрүүлгийн нийт 48 удаагийн дугаар бэлтгэж, 12 телевизээр 96 удаагийн давталттайгаар дамжуулан иргэд, олон нийтэд түгээсэн.

“Police podcast” хөтөлбөрийн хүрээнд 11, “Ярилцах цаг” хөтөлбөрийн хүрээнд 5 удаагийн ярилцлагыг бэлтгэн түгээсэн байна.

**2.9.Зохион байгуулсан спорт, урлагийн арга хэмжээний чиглэлээр:** Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын тогтоол, шийдвэрийн хүрээнд цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын дунд 15, ахмад ажилтнуудын дунд 3, байгууллагыг иргэд, олон нийтэд сурталчлах 2, нийт төлөвлөгдсөн 20 төрлийн спортын уралдаан, тэмцээн зохион байгуулахыг зогсоосон.

Монгол Цэргийн өдөр, Зэвсэгт хүчний түүхт 100 жилийн ойд зориулсан төрийн цэргийн болон хууль сахиулах тусгайлсан чиг үүрэгтэй 14 байгууллагын удирдах бүрэлдэхүүний дунд болсон буудлага, биллиард, гар бөмбөгийн “Нөхөрсөг-уулзалт” тэмцээнд амжилттай оролцож тэргүүн байрт шалгарсан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн А/209 дүгээр тушаалаар 521 удирдах албан тушаалтны бие бялдрын шалгуур үзүүлэлт, норматив түвшинг тогтоосон.

Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2021 оны А/28 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн цахим гүйлт 2021” биеийн тамирын арга хэмжээнд цагдаа, дотоодын цэргийн 52 анги, байгууллагын 923 алба хаагч, ажилтан, сонсогч нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн багт оролцож, 23279.5 км зам туулж оролцсон.

Хүч спорт хорооны дасгалжуулагч, цагдаагийн ахмад, МУГТ М.Уранцэцэг “Токио-2020” зуны олимпын XXXII наадамаас 1 хүрэл, Олон Улсын жүдо бөхийн холбоо /IJF/-ны цуврал “Доха Мастерс 2021”, “Ташкентын гранд слам”, “Тбилисийн гранд слам”, Унгар Улсын Будапешт хотноо зохион байгуулагдсан жүдо бөхийн насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 2 алт, 2 хүрэл, цагдаагийн ахлах ахлагч, МУГТ Э.Бэхбаяр Болгар Улсын Софи хотноо зохион байгуулагдсан “СОФИ-2021” тэмцээнээс мөнгө, цагдаагийн дэд ахлагч, ОУХМ Т.Тулга Итали Улсын нийслэл Ром хотноо зохион байгуулагдсан Дэлхийн чансааны оноо олгох Маттео Пелликонегийн нэрэмжит “А” зэрэглэлийн Олон улсын тэмцээнээс мөнгө, “Осло-2021” чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль тус тус хүртсэн.

Беларусь Улсын нийслэл Минск хотноо зохион байгуулагдсан Олон Улсын Таеквондогийн холбоо /ITF/-ны 55 жилийн ойн нэрэмжит өсвөрийн болон мастер ангиллын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс ахмад ажилтан, цагдаагийн бэлтгэл ахмад

М.Төрбаяр -80 кг-ын жинд алт, багийн тулааны болон хатуу биет эвдэх төрөлд мөнгө, хүрэл, ахмад ажилтан, цагдаагийн бэлтгэл ахлах дэслэгч А.Чагцал +75 кг-ын жинд алт, багийн тулааны болон хатуу биет эвдэх төрөлд хошой алтан медаль тус тус хүртсэн.

Монголын зохиолчдын эвлэлтэй хамтран 38 дахь удаагийн “Болор цом” яруу найргийн наадам, “Цагдаагийн байгууллагын 100 жил” сэдэвт блок марк, “Түүх мартахагүй” кино концерт, “Эрхэм төрийн тамгат баатрууд” түүхэн дуулалт дууль дэглэж, “Цагдаагийн бахархалт 100 үзмэр”-ийг багтаасан виртуал музей байгуулан үзэгчдийн хүртээл болгосон.

### **Гурав. Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний ажлын талаар**

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагч, ажилтны гэнэтийн ослын даатгалын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр “Ард даатгал” ХХК-тай 122.9, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр “Номин даатгал” ХХК-тай 175.0, үл хөдлөх хөрөнгийн даатгалын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр “Номин даатгал” ХХК-тай 61.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, албан үүргээ гүйцэтгэж яваад бэртэж, гэмтсэн 117 алба хаагчид 225.7 сая, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөрт 107 тохиолдолд 259.9 сая, үл хөдлөх хөрөнгийн даатгалд 7 барилга, байгууламжийн засварт 75.2 сая төгрөгийн нөхөн төлбөр олгогдсон.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны төсвийн урсгал санхүүжилтийн зардалд 253.5, хөрөнгө оруулалтын зардалд 8.3 нийт 261.9 тэрбум төгрөгийг баталсан ба үүний 168.2 тэрбум төгрөг буюу 64.2 хувь нь цалин, ажил олгогчоос төлөх эрүүл мэндийн даатгалын зардал, 8.3 тэрбум төгрөг буюу 3.2 хувь нь хөрөнгө оруулалтын зардал, 67.2 тэрбум төгрөг буюу 25.7 хувь нь урсгал зардал, 18.1 тэрбум төгрөг буюу 6.9 хувь нь тэтгэмжийн зардал байна.

Цагдаа, дотоодын цэргийн бие бүрэлдэхүүнээс шөнийн ээлжид ажилласан алба хаагчдад олгох хоолны мөнгийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны “Хүнс хангалтын тухай” А/114 дүгээр тушаалаар 5000 төгрөг байсан хоолны мөнгийг 10.000 төгрөг болгон нэмэгдүүлэн батлуулж, 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн.

Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн дуудлага, мэдээллийн холболтын систем, тоног төхөөрөмжийн 240.0 сая зардлыг шийдвэрлэж, шинээр цагдаагийн байгууллагын мэдээллийн систем, мэдээлэл нэгтгэн боловсруулах программыг нэгдмэл байдлаар боловсруулах, Мэдээллийн аюулгүй байдал, сүлжээний тоног төхөөрөмж, программ хангамж, лицензийг 850.0 сая төгрөгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын автопаркийг шинэчлэх ажлын хүрээнд тусгай дуут гэрлэн дохио, техник хэрэгслээр тоногдсон 5 төрлийн 289 автомашиныг хүлээн авч хуваарилан олгосон.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/212 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-ний нэгдүгээр хавсралтад хөрөнгө оруулалт 8.4 тэрбум, хоёрдугаар хавсралтад урсгал төсөвт 18.4 тэрбум төгрөг тус тус тусгагдсан бөгөөд тухайн төлөвлөгөөний хүрээнд давхардсан тоогоор нийт 32 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилга, 30 үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) болон өдөр тутмын сонин хэвлэлд холбогдох хууль, журмын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/321 дүгээр тушаалаар цагдаагийн алба хаагчдын 2021 оны хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий “Үнэлгээний хороо”-г 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, төлөвлөгдсөн 40 багц /39 нэр төрөл/-ын 7.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “ЦЕГ/202112016” дугаартай тендер шалгаруулалтыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зарлаж, шалгарсан дотоодын 20 аж ахуйн, нэгж байгууллагаар нийт 7.5 тэрбум төгрөгөөр бэлтгүүлэхээр шийдвэрлэж, 302.4 сая төгрөгийн хэмнэлт гаргасан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/320 дугаар тушаалаар Дотоодын цэрэг болон хугацаат цэргийн алба хаагчдын 2021 оны хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдгийг бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, 43 нэр төрлийн 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй дүрэмт хувцас, ялгах тэмдгийг бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэгчээр дотоодын 19 аж, ахуйн нэгж байгууллагаар 42 нэр төрлийн барааг нийт 1.0 тэрбум төгрөгөөр бэлтгүүлэхээр шийдвэрлэж, 135.0 сая төгрөг хэмнэсэн.

## **Дөрөв. Дүгнэлт**

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 оны үйл ажиллагаанд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2021 оны 1 дүгээр улиралд хяналт-шинжилгээ хийж, өгсөн үнэлгээгээр харьяа агентлаг, байгууллагуудаас нэгдүгээр байрт шалгарсан.

-Хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүрэг, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.

-Бүх шатны удирдах албан тушаалтан, дунд офицер, ахлагч бүрэлдэхүүний сургалт зөвлөгөөнийг анх удаа цахимаар амжилттай зохион байгуулсан.

-Улсын хэмжээнд нийт 25429 гэмт хэрэг бүртгэгдсэний 65.0 хувь нь нийслэлд, 34.9 хувь нь орон нутагт, 0.1 хувь нь бусад газар /хилийн чанадад/ бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад гэмт хэрэг 10.3, нийслэлийн хэмжээнд 13.0, орон нутагт 5.5, бусад газар /хилийн чанадад/-т 36.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит, Улсын Их Хурлын нөхөн сонгууль, гадаадын зочид төлөөлөгчдийн айлчлал, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас иргэд, олон нийтийг урьдчилан сэргийлэх хамгаалалт, зохицуулалтыг тус тус зохион байгуулсан.

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**